



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/172

Мандалговь

“ДӨЛ БГМ” ХХК-тай гэрээ
байгуулах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн А/92 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Луус сумын сургуулийн дээврийн засварын ажил”-ын гүйцэтгэгч “ДӨЛ БГМ” ХХК-тай 52,500,000 (Тавин хоёр сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу “Луус сумын сургуулийн дээврийн засварын ажил”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “ДӨЛ БГМ” ХХК-ны захирал (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Луус сумын сургуулийн захирал (Н.Долгоржав), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190483